Үндэсний аюулгүй байдлын гол цөм болсон хүний аюулгүй байдал нийгэмд чухал байр суурь эзэлж байгаа энэ үед хил хамгаалах байгууллага нийгмийн чиг хандлагыг дагаж цэргийн алба хаагч төвтэй цэргийн албаны харилцааг хөгжүүлэх хилийн анги, отрядыг хүний хөгжлийн төв болгон ажилуулж цэргийн алба хаагчдыг аливаа аюул заналаас хамгаалах явдал чухал учраас тэдний алба хаах аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх аюулгүй байдлыг нь бүх талаар хангах нь зүй ёсоор тавигдаж байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*акаде.иийн 821 дүгээр дамжааны суралцагч,*
*хошууч Э.Майдар*

# ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр Монгол Улсад хил хамгаалах байгууллагын удирдлага зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж цаашид хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг сайжруулахад өөрийн саналаа дэвшүүлсэн болно.*

***Түлхүүр*** *үг. Удирдлага, зохион байгуулалт, бүтэц, бүс нутаг, бүсчилсэн хил хамгаалалт, оператив удирдлага.*

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд гарсан нэг чухал үйл явдал бол Монгол Улсын хил халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслэлийг нэвтрүүлэхэд, орон нутгийн байгууллагыг өргөн оролцуулах, хил зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий Хилийн тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа явдал юм.

Хилийн тусгай анги улсын хилийн дэглэм, хил орчмын дэглэмийн сахилгыг тухайн чиглэл, хэсэгт хэрэгжүүлэх үндсэн хүч учраас улсын хил дээр тайван цагт гарсан бүх асуудлыг хууль эрх зүйн дагуу үр ашигтай шийдвэрлэхээс гадна улсын хил дээр гарсан хилийн будлианыг цэрэг, дипломатын аргаас гадна цэргийн хүч хэрэглэж түүнийг ашигтайгаар шийдвэрлэх аргыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хариуцсан хэсэгт хангасан байх шаардлагатай.

Хил хамгаалах байгууллагын удирдах байгууллага нь Монгол Улсын хилийг хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хил хамгаалах, салбар нэгжүүдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, удирдамж чиглэл үүрэг даалгавараар хангана.

Хил хамгаалах байгууллагын бүтэц тогтолцоо, чиг үүргээс үндэслэн Хил хамгаалах удирдлагын Үйл ажиллагаа нь хилийн манаа + хилийн харуул + застав + отряд + ХХЕГ + ЗГ гэсэн нэгэн шугамаар хэлхэгдсэн хүн /хүний нөөц/ + техник /холбооны хэгсэл/ + байр (суурин ба хөдөлгөөнт зангилаа) гурван нэгжийн цогц болох нь тодорхой[1]. Өөрөөр хэлбэл улсын хил дээр илэрсэн хилийн зөрчил, ямар нэгэн аюулын заналын мэдээг хилийн манаанаас эхлэн харуул. застав, отряд хил хамгаалах төв байгууллага буюу Хил хамгаалах ерөнхий газраас дамжигдан засгийн газарт хүрч тэндээс эргэх холбоогоор улсын хил дээр удирдамж, үүрэг хэлбэрээр хүрч байна гэсэн үг.

Хил хамгаалалтын удирдлагын орон зайд дарга захирагч нарын эзлэх жинг авч үзвэл хамгийн цөөн нь хилийн цэргийн командлагч ээлж бусад нь өсөх байдлаар дээшилсээр хамгийн олон нь хилийн манааны ахлагч, арай наашлуулбал харуулын даргад оногдож байна. Энэ нь хилийн манааны ахлагчийн бодол, үйлдлээр хил хамгаалах байгууллагын удирдлагын шийдвэрийн чанар илэрч байна гэсэн үг.

Өөрөөр хэлбэл хилийн цэргийн командлагчийн шийдвэр нь дамжсаар анхан шатны нэгж рүү шилжих маягаар явсаар хилийн манааны ахлагчийн шийдвэрээр хэрэгждэг нь харагдаж байна.

Өргөн утгаар нь авч үзвэл төрөөс хил хамгаалах талаар баримталж байгаа бодлого хуулийн хэрэгжилт эцсийн эцэст хилийн манааны үүрэг гүйцэтгэлтийн үр дүнгээс, түүний хувь заяа нь хилийн манааны ахлагч, харуулын даргын шийдвэрээс шалтгаалж байна. Хил хамгаалах байгууллагуудын дарга /захирагч/ нарын удирдлагын үйл ажиллагаа эрх үүрэг холбогдох хууль дүрмээр баталгаажсан байдаг тул улсын хил дээр эдгээр нь бие даан шийдвэр гарах онцгой эрх эдэлдэг онцлогтой.

Үүнтэй холбогдуулан 1997 оноос хил хамгаалах байгууллагыг БХЯ-ны бүтцээс гаргаж хууль зүйн яаманд харъяалуулж бие даасан тогтолцоотойгоор үйл ажиллагаагаа явуулах болсноор түүний нэгж байгууллагуудын үйл ажиллагаа боловсронгуй болгох нөхцөл үндсэндээ бүрдсэн гэж үзэж байна.

Монгол Улсын хилийн асуудал нь олон улсын 40 гаруй конвенц, гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын 20 гаруй хуулиар зохицуулагддаг, улс төр, дипломат, эрх зүй, тагнуул, цэрэг техникийн болон дэглэм сахиулах арга хэмжээний цогц болно.

[1] *Ц.Цэрэндорж.* Хил хамгаалах байгууллагын менежментийг боловсронгуй болгох. - УБ. 2003.

Хуулийн заалтаас дүгнэн үзвээс хил хамгаалах байгууллага нь төрийн захиргааны байгууллага (ХХЕГ) тусгай анги (отряд) салбар тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үндсэн зорилгод зангигдсан нэгдмэл тогтолцоо юм.

Хил хамгаалах байгууллагын салбар тогтолцоо нь хамгаалж буй хэсгийн хэмжээ, орон нутгйин онцлог, газар зуйн байршил, төв суурин газраас алслагдсан байдал, хил залгаа улсын хилээ хамгаалж байгаа хэрэгсэл, арга тактик зэргээс хамааран хүч, техник хэрэгсэл, хангалт үйлчилгээ, тэдгээрийн онцлог нөхцөлд зохицсон байх нь хил хамгаалах байгууллагын менежментийн чухал зорилт юм.

Энэ талаар цэргиин шинжлэх ухааны доктор Ш.Арвай “Хил хамгаалах харилцах тодорхой, байнгын шинж хадгалдаг учраас үндсэн хүчний дийлэнх хэсэг нь хил хамгаалах салбарт төвлөрдөг бөгөөд хил хамгаалах байгууллагын тогтолцоо бүтэц, хүч хэрэгсэл, хөрөнгийн эзлэх байрлал, шинж нь улсын хилд үйлчлэх бүлэглэлтэй, цуваажсан байрлалтай, улсын хилээс гүн рүүгээ чиглэсэн гурвалжин хэлбэрийн агуулгад багтаж байвал илүү оновчтой, үр ашигтай шинж байдлыг хадгалдаг” гэж тэмдэглэсэн.

Энэ асуудлын хариу нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хил хамгаалах байгууллагын тогтолцоо, дунд түвшний удирдлага буюу бүс нутгийг хамгаалах газрыг шинээр бий болгохыг үгүйсгэх аргагүй юм[1].

Хил хамгаалах ерөнхий газрын удирдлага зохион байгуулалтын бүтцийг аль болох чадварлаг болгож, удирдлагын шат дамжлагыг дээд буюу улс орны, дунд буюу бүс нутгийн, доод буюу хил хязгаарын гэсэн байдлаар асуудлыг шуурхай шийдвэрлэж аливаа эрсдлээс хамгаалах, түүнээс хохирол багатай гарах нөхцөл бүрдүүлэхийн тулд хүн, үр дүнд мэргэжлийн байдалд чиглэсэн шинэ загвар бүтцийг боловсруулах.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, мянганы замын босоо, хэвтээ тэнхлэг болон дэд бүтцийн хөгжлийн стратегийн төлөвийг харгалзан хилийн оператив буюу дунд түвшний удирдлага Бүс нутгийн удирдах газрыг бүсчилсэн хөгжлийн тулгуур төвүүдийг түшиглэн байгуулж ажиллуулах нь улсын хилийн хамгаалалттай холбоотой аливаа асуудлыг улс төр -дипломатын аргаар, энхийн журмаар шийдвэрлэх хандлага давамгайлж байгаа өнөө үед ихээхэн ач холбогдолтой бөгөөд цаашид хилийн асуудлыг зохицуулах, шийдвэрлэх үндсэн арга нь болохыг харгалзан үзэх шаардлагатай байна.

[1] *Ц.Цэрэндорж.* Хил хамгаалах байгууллагын менежментийг боловсронгуй болгох. УБ. 2003.

ОХУ-ын судлаачид "Хилийн бүс нутаг нь нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч тоо, талбайн хувьд янз бүр байна" гээд "жижиг улсууд хилийн бүс нутагт хуваагдахгүй хилийн секторт хуваагдаж болох юм. Дунд зэргийн нутаг дэвсгэртэй улсууд , хилийн баруун, зүүн, хойд, өмнөд гэсэн 4 бүс нутагт хуваагдах нь тохиромжтой" гэсэн бодомжийг Монгол Улсын хувьд сонгож байна. Мөн өмнө нь ч ингэж бүсчилж байсан[1].Бүс нутгийн удирдах газрыг өмнө нь байгуулагдаж байсан хилийн төлөөлөгчийн газрын бааз. суурийг харгалзах бөгөөд үүний дээр ажиллагаа. эрх, үүргийн хувьд илүү өргөн, харъяа отрядуудын үйл ажиллагааг чиглүүлэх, хянах, зааварчлах, шалган туслах үүрэг бүхий оперативын удирдлагын нэгжийн хэмжээнд ажиллаж болох юм.

Бүс нутгийн удирдах газрыг хилийн орон зайд улсын хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний үр ашгийг дээшлүүлэх, удирдлагыг цэрэгт аль болох ойртуулах, цэргийг удирдах нөхцлийг сайжруулах, төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэхэд оролцогч төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, цэргийн оператив, байлдааны болон тусгай бэлтгэлийг чанартай зохион байгуулах зорилготойгоор хийх.

Бүс нутгийн удирдах газар нь бэлтгэл хүчтэй, хангалтын баазтай, нисдэг тэрэгтэй, нэгдсэн хангалт үйлчилгээ, засварын бааз, хэрэг бүртгэх, тагнуулын албатай, бүс нутагт хилийн цэргийн удирдлагыг хангах үүрэгтэй, цэргийг удирдах өдөр тутмын үйл ажиллагаанаас нь ХХЕГ-ыг ангижруулсан, хил хамгаалалтын талаарх төр, улсын бодлогыг боловсруулахад тус болохуйц, харъяа отрядын өдөр тутмын асуудлыг шийдвэрлэдэг удирдлагын бие даасан нэгж байх ёстой гэж үзэж байна.

Хилийн цэрэг үүсэн байгуулагдаж улсын хилийн хамгаалж ирсэн 83 жилийн хугацаанд хил хамгаалалтын удирдлагын үйл ажиллагаа хууль эрх зүй, дүрэм, журам заавруud цаг үеийн шаардлагыг даган өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн боловч өнөөгийн шаардлага, нийгмийн хөгжлийн хурд, хилийн цагийн байдлын өрнөлт, цаашдын төлөвд тохируулан боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч байна.

Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах цогцолбор бодлоготой салшгүй холбоотой, бүрэлдэхүүн хэсэг нь болсон улсын хил хамгаалалт, үйл ажиллагаанд шууд нөлөөлөх бодит хүчин зүйл болдог онцлогтой.

Орчин үеийн дэлхий нийтийг хамарсан үйл явц болох даяарчлалын

[1] *Н.Наранжамц.* Бүс нутаг, хил хамгаалалтын үзэл баримтлал. УБ. 2012.

ур дагавар, нөлөөгөөр улс дамнан алан хядлага үйлдэх, улсын хил давуулан хар тамхи, цөмийн болон химийн зэвсгийн түүхий эд, зэвсэг, хүн наймаалах, захиалгат аллага, мөнгө угаах, төрөл бүрийн халдварт өвчин тараах, хил орчмын нутаг дэвсгэрийн гэмт хэргийн элементүүд болон зохион байгуулалтанд орох зэрэг үйлдлүүд ихсэх болсон цагийн байдлын өөрчлөлт, өрнөлт, хэтийн төлөвөөс дүгнэлт хийвэл хил хамгаалалтын удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгох, үр өгөөж, үр дүнг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр өргөн уудам, улсын хил олон мянган километр үргэлжилсэн урт, хүн ам цөөн, хил орчмын нутаг дэвсгэр үндсэндээ эзэмшилгүй ийм нөхцөлд улсын хилийг дан ганц хил хязгаарын буюу тактикийн түвшинд цэрэгжүүлсэн хамгаалалтаар хамгаалах боломжгүй юм.

Өнөөгийн нөхцөлд хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагын тогтолцоог өөрчлөх удирдлагын шат дамжлагыг” стратегийн дээд буюу улс орны, оперативын дунд буюу бүс нутгийн, тактикийн доод буюу хил хязгаарын” гэсэн байдлаар асуудлыг шуурхай шийдвэрлэж аливаа эрсдлээс хамгаалах, түүнээс хохирол багатай гарах нөхцөл бүрдүүлэхийн тулд хүн, үр дүнд мэргэжлийн байдалд чиглэсэн шинэ загвар бүтэцийг тогтоож, цаашид хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох дээшлүүлэхэд чиглэсэн аргачлал, зөвлөмж боловсруулж, санал дэвшүүлэв.

1. Бүс нутгийг удирдах газрыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг харгалзан хилийн-захиргааны дөрвөн бүсчлэлээр байгуулах шаардлагатайг тооцож, "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай" хууль, "Бусүүдийн хөгжлийн 2010 хүртлэх дунд хугацааны стратеги", мянганы замын босоо, хэвтээ тэнхлэг болон дэд бүтцийн хөгжлийн стратегийн хэтийн төлөвийг харгалзан “Бүс нутгийн удирдах газар”-ыг байгуулан ажиллуулах нь хил хамгаалах албаны хэт төвлөрсөн удирдлагын тогтолцоог өөрчлөж, хилийн бүс нутгийн хөгжил, нийгэм-эдийн засгийн чиг хандлага, нөөцүүдийг тооцож хамгаалалтыг зохион байгуулах ихээхэн ач холбогдолтой болно.

2. Бүс нутгийг удирдах газрыг бий болгосоноор мэргэжлийн удирдлагаар хангагдан, үүрэг хариуцлага нь дээшилж, мэргэжлийн чадвар нь сайжирч, мэргэжих чиг хандлагыг бий болж, Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэрийг хязгаарлан тодорхойлж буй улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн онцлогыг үл харгалзан нэг хэв загварын хил хамгаалалтын тогтолцоог өөрчлөх, төвөөс хэт хамааралтай уднрдлагын

үйл ажиллагааны шуурхай биш байдал хилийн анги салбарын удирдлагуудад хүлээлт бий болгох байдал үгүй болно.

3. Бүх төрлийн хангалт, түүний дотор албаны хангалтын тоггвортой тасралтгүй байдлыг хангах талаар нэгдмэл тогтсон системтэй болж, оператив-тактикийн удирдлагын төсвөөс хамааралтай хангалт үйлчилгээний хүрэлцээгүй байдал арилж анги салбарын үйл ажиллагааг хил хамгаалалтыг зохион байгуулах үндсэн үүргээс нь хөндийрүүлж, цэргийн өдөр тутамын сургалт, бэлэн байдлыг эрхэмлэх мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа алдагдахгүй улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангахад чиглэгдэнэ.

Хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох хүрээнд дэвшүүлсэн асуудлыг цогцоор шийдвэрлэснээр хил хамгаалах байгуулалагын эрх зүйн, зохион байгуулалтын, удирдлагын, бүтцийн, мэргэжлийн, албаны болон ахуй хангалтын орчин бүрдэж, дэвшүүлсэн зорилтууд үндсэндээ шийдвэрлэгдэж, үйл ажиллагаа нь тавигдаж буй шаардлагын шинэ түвшинд хүрч улсын хил хамгаалалтыг мэргэшсэн удирдлагаар илүү үр дүнтэй хамгаалах арга болон төлөвших юм.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны суралцагч,*
*хошууч Я.Гантө.мөр*

## ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ДОТООДЫН ХҮЧИН ЗҮЙЛС, ТҮҮНД хийх шинжилгээ

***Хураангуй.*** *Хилийн аюулгүй байдал нь тодорхой орон зай дахь үндэсний ашиг сонирхлын аюулгүй байдлаар голчлон тодорхойлогдож, аюулгүй байдлын бусад бүрэлдэхүүнд шууд нөлөөлж байдаг. Хилийн аюулгүй байдлыг хангах дотоод таатай нөхцөл бүрдүүлэх нь улс, нийгмийн хөгжил хил орчмын нутагт давуутай байж, энд оршин суугчдын материалын болон оюун санааны эрэлт хэрэгцээ бололцооны дээд хэмжээгээр хангагдсан, үндэстэн, ястны бат бэх нэгдэлтэй байдал, аюулгүй орчин бурэлдэж бий болсон нөхцлийг хэлж болно.*

***Түлхүүр үг.*** *Улсын хил, хилийн аюулгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэр, дотоод гадаад хүчин зүйл.*

Үндэсний аюулгүй байдал нь олон элементийг агуулдаг бөгөөд хилийн аюулгүй байдал бол үндэсний аюулгүй байдлын уламжлалт нэг чухал элемент юм. Олон улсад хилийн орон зайд төр, нийгэм,